



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 15 өдөр

Дугаар А/526

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 14/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4 дэх заалтыг хэрэгжүүлж, Мөнххайрхан суманд зохион байгуулагдах Альпинат авиралтын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах зардалд 10,000,000 (арван сая) төгрөгийг нэгдүгээр хавсралтаар, авиралтад оролцох Ховд аймгийн уулын баг тамирчдын хувцас хэрэгслийн зардалд 3,520,000 (гурван сая таван зуун хорин мянга) төгрөгийг хоёрдугаар хавсралтаар баталж, дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх үйл ажиллагаанд зарцуулагдах 13,520,000 (арван гурван сая таван зуун хорин мянган төгрөг) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 1284

Zah A/526 Kh

Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 25-ны өдрийн
А/526 дугаар захирамжийн
нэгдүгээр хавсралт

МӨНХХАЙРХАН СУМАНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЛЬПИНАТ АВИАЛТЫН
УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Төсөв | Тоо ширхэг | Нэг бүр үнэ | Нийт үнэ |
|----------|--|------------|-------------|------------|
| 1 | 1 дүгээр байрын шагнал | 2 | 500,000 | 1,000,000 |
| 2 | 2 дугаар байрын шагнал | 2 | 400,000 | 800,000 |
| 3 | 3 дугаар байрын шагнал | 2 | 300,000 | 600,000 |
| 4 | Тусгай байрын шагнал | 2 | 200,000 | 400,000 |
| 5 | Медалийн зардал | 50 | 20,000 | 1,000,000 |
| 6 | Батламж | 8 | 2800 | 22,400 |
| 7 | Нээлтийн үйл ажиллагаанд оролцох хөтлөгч, уран бүтээлчдийн урамшуулал (Dj, уран бүтээлч) | 2 | 1,500,000 | 3,000,000 |
| 8 | Оролцогчдын мандатын иж бүрдэл (оосор, хавтас, хэвлэл) | 350 | 2500 | 875,000 |
| 9 | Кемпийн тог гаргах моторын түрээсийн зардал | 18 цаг | 70,000 | 1,260,000 |
| 10 | Шатахууны зардал | 75 | 3900 | 292,600 |
| 11 | Зурагчин, видео контентын зардал | 1 | 750,000 | 750,000 |
| Нийт дүн | | | | 10,000,000 |

-oOo-

Засаг даргын 2024 оны
07 дугаар сарын 25-ны өдрийн
А/526 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт

АВИРАЛТАД ОРОЛЦОХ ХОВД АЙМГИЙН УУЛЫН БАГ ТАМИРЧДЫН ХУВЦАС
ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Төсөв | Тоо ширхэг | Нэг бүр үнэ | Нийт үнэ |
|----------|--|------------|-------------|-----------|
| 1 | Оролцогчдын оролцох эрхийн төлбөр | 20 | 90,000 | 1,800,000 |
| 2 | Скайрангийн оролцогчийн төлбөр | 20 | 20,000 | 400,000 |
| 3 | Техникийн авиралтын оролцогчийн төлбөр | 20 | 50,000 | 1,000,000 |
| 4 | Шатахууны зардал | 8 л | 3,900 | 320,000 |
| Нийт дүн | | | | 3,520,000 |

-оОо-